

БАТЛАВ
АЙМГИЙН БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ
ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН ДАРГА
Н.ГАНТУЛГА

АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ ГЭРЭЭ

2023 оны 08 дугаар
сарын 01-ны өдөр

№. ДУБОАЖГ/202302.

Мандалговь хот

НЭГ. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

1.1 Дундговь аймгийн Засаг дарга, Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын хооронд 2023 онд Байгаль орчин, аялал жуулчлалын салбарт хамтран ажиллах № 23-010 тоот гэрээний 1 дүгээр хавсралтын 7.3 дэх заалтын хэрэгжилтийг хангаж, байгаль хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зардлаар “Уяхан Замбуу Тивийн Наран” эвент арга хэмжээг хамтран гүйцэтгэхэд энэхүү гэрээний зорилго оршино.

1.2 Энэхүү гэрээг нэг талаас Дундговь аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газар (цаашид Захиалагч гэх) нөгөө талаас “Алтанбэрс ХХК” (цаашид Гүйцэтгэгч гэх) нар Дундговь аймагт Байгаль орчин, аялал жуулчлалын салбарын бодлого зорилтыг хангах, Уяхан замбуу тивийн наран – урлагийн их наадмыг зохион байгуулахад шаардлагатай хэвлэл, тохижилтын ажлыг хэрэгжүүлж, гадаад, дотоодын жуулчдыг үзэх зүйлсийг зохион байгуулахад тус ажлыг гүйцэтгэхтэй холбоотой захиалагч, гүйцэтгэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулна.

ХОЁР. ТАВИГДАХ ШААРДЛАГА

2.1 Гурвансайхан сумын “Их газрын чулуу” байгалийн цогцолбор газарт “Уяхан замбуу тивийн наран” эвент арга хэмжээг зохион байгуулахад тохижилтын ажлыг хамтран зохион байгуулах.

2.2 “Уяхан замбуу тивийн наран урлагийн их наадам”-ын гадаад, дотоодын жуулчид үзэх орчин, нөхцөл бүрдүүлэх, нүүдэлчин уламжлалт соёлыг харуулах тохижилт, хэвлэлийг хийж гүйцэтгэсэн байх.

2.3 Уяхан замбуу тивийн наран урлагийн их наадмын мэдээллийн самбар, хашаа хашлагыг бэлтгэж, туг далбаа, гэрэлт хаяг байрлуулсан байх.

ГУРАВ: ЗАХИАЛАГЧИЙН ЭРХ, ҮҮРЭГ

3.1 Захиалагч нь гүйцэтгэгчээс гэрээт ажлын явцад хяналт тавьж, эцсийн гүйцэтгэлийн тайланг гаргуулан авах.

3.2 Захиалагч нь гүйцэтгэгчийн гүйцэтгэсэн ажлын үр дүн чанарын шаардлага хангаагүй, батлагдсан гэрээг зөрчиж буруу гүйцэтгэсэн бол гүйцэтгэгчийн зардлаар доголдлыг арилгуулах, эсвэл ажлыг шинээр гүйцэтгүүлэх.

3.3 Гүйцэтгэгч талд гэрээнд тусгагдсаны дагуу санхүүжилтүүдийг олгох.

ДӨРӨВ: ГҮЙЦЭТГЭГЧИЙН ЭРХ ҮҮРЭГ

4.1 Гүйцэтгэгч нь гэрээнд тусгагдсан ажлыг чанартай сайн хийж гүйцэтгэнэ.

4.2 Гүйцэтгэгч нь “Уяхан Замбуу Тивийн Наран” арга хэмжээний гадна хэвлэлийг хийж суурилуулан, захиалагчид хүлээлгэн өгнө.

4.3 Гэрээт ажлын гүйцэтгэлийг цаг хугацаанд нь чанартай гүйцэтгэж, захиалагчийн өнгө загварын дагуу чанарын өндөр түвшинд хийж гүйцэтгэж хүлээлгэн өгнө.

4.4 Ажил гүйцэтгэх газрын талаар шаардлагатай мэдээлэл, зураг гаргуулж авч болно.

4.5 Гэрээнд заасан ажлыг хийж гүйцэтгэснийхээ төлбөрийг захиалагч талаас авах.

ТАВ. ГЭРЭЭНИЙ ХУГАЦАА

5.1 Гурвансайхан сумын “Их газрын чулуу” байгалийн цогцолбор газарт “Уяхан замбуу тивийн наран” эвент арга хэмжээг зохион байгуулахад тохижилтын ажлыг гүйцэтгэхэд захиалагч болон гүйцэтгэгчийн харилцааг зохицуулахад 2 тал гарын үсэг зурж, тамга дарагдсан өдрөөс хүчин төгөлдөр мөрдөгдөнө.

5.2 Гэрээт ажлыг 2023 оны 08 дугаар сарын 11, 12-ны өдөр гүйцэтгэх бөгөөд уг гэрээ нь 12 дугаар сарын 10-ыг хүртэл хүчинтэй.

ЗУРГАА. ГЭРЭЭНИЙ САНХҮҮЖИЛТ

6.1 Гэрээт ажлын нийт өртөг 10,000,000 /арван сая төгрөг/ бөгөөд захиалагч нь ажлыг хийж гүйцэтгэхэд шаардлагатай төлбөрийг энэхүү гэрээ хүчин төгөлдөр болсны дараа гүйцэтгэгчид олгоно.

6.1.1 Гүйцэтгэгч санхүүжилт хүссэн тухай нэхэмжлэх

6.3 Захиалагч нь гэрээний дагуу санхүүжилтийг гүйцэтгэгч болох “Алтанбэрс ХХК”-н Капитрон банк дахь 3020004891 тоот дансанд шилжүүлнэ.

6.4 Төлбөр төлөх хугацаа хэтэрсэн хоног тутамд нийт ажлын үнийн дүнгийн 0.5% алданги тооцож төлбөр ногдуулна. Энэ нь гүйцэтгэгчийн хийх ажлын нийт төлбөрийн 20%-иас хэтрэхгүй байна.

ДОЛОО. ДАВАГДАШГҮЙ ХҮЧИН ЗҮЙЛ

7.1 Гүйцэтгэсэн ажлын үр дүн Захиалагчид хүлээлгэж өгөхөөс өмнө гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй нөхцөл байдлын улмаас тухайн ажлын үр дүн устсан, гэмтсэн тохиолдолд бий болох эрсдэлийг ажил гүйцэтгэгч хариуцна.

7.2 Гүйцэтгэсэн ажлын үр дүнг захиалагч хугацаанд нь хүлээж аваагүй бол ажлын үр дүн ажил гүйцэтгэгчийн эзэмшилд байсан ч гэсэн гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй нөхцөл байдлын улмаас бий болох үр дагаврыг Захиалагч хариуцна.


НАЙМ. МАРГААН, ГӨМДӨЛ

9.1 Энэхүү гэрээний биелэлт, үнэлэлтийн талаар гомдол, маргаантай асуудал гарвал хоёр тал албан харилцааны хүрээнд эвийг эрхэмлэн шийдвэрлэнэ. Харин харилцан шийдэлд хүрээгүй тохиолдолд хуулийн дагуу шийдвэрлүүлнэ.

ЕС. ГЭРЭЭНИЙ БАТАЛГААЖУУЛАЛТ

ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН
МЭРГЭЖИЛТЭН


Б.БАТХҮҮ

Хаяг: Дундговь аймаг, Сайнцагаан сум,

7 дугаар баг, Буяаннэмэхийн өргөн
чөлөө 1 - 105 тоот

Утас 70593988 89006844

Банкны нэр: Төрийн сан

Харилцах данс: 100080013001

РД: 9035273

ГҮЙЦЭТГЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

“Алтанбэрс ХХК”

ЗАХИРАЛ


Т.ЭРДЭНЭМАНДАЛ

Хаяг: Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг

9-р хороо, SPS барилга 101 тоот

Утас 9911-9106, 7011-8830

Банкны нэр: Капитрон банк

Харилцах данс: 3020004891

РД: 5330629

Хянасан:

Аймгийн Засаг даргын тамгын газрын
Хууль, эрх зүйн хэлтсийн мэргэжилтэн

..... Б.Энхмандал

